



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/159

Хэрлэн сум

Удирдах зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5.-ын "а", 29.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 50 дугаар тогтоол, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын "Журам батлах тухай" 2011 оны 297 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам"-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдэд эм зүйн тусламж үйлчилгээг тасралтгүй жигд хүртээмжтэй хүргэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

Удирдах зөвлөлийн дарга:

Ц.Гэрэлмаа

-Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:

Г.Лхагвахатан

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ц.Дэмбэрэлсайхан

-Орон нутгийн өмчийн албаны дарга

Д.Оюунтуяа

-Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч

Н.Бадрангуйтөгс

-Мэргэжлийн хяналтын газрын эм биобэлдмэлийн чанарын хяналтын улсын байцаагч

Г.Энх-Амгалан

-Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн Эрүүл мэндийн даатгалын тасгын дарга, магадлагч эмч

Д.Энхтуяа

-Монголын эмзүйн нэгдсэн Эм Холбооны Хэнтий аймаг дахь эм холбооны гишүүн /зөвшилцсөнөөр/

Р.Байгалмаа

-Иргэдийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Б.Арвинтунгалаг

-Эрүүл мэндийн газрын эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

01 741

2. Орон нутагт эмийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж үнэлгээ өгөх, стандартыг хэрэгжүүлэх, санхүүгийн тайланг хянан хэлэлцэж, дүгнэж ажиллахыг удирдах зөвлөлийн дарга /Ц.Гэрэлмаа/-д даалгасугай.

3. Эмийн эргэлтийн сангийн хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2015 оны А/168 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА